



**ЗАМ, ТЭЭВЭР, БАРИЛГА,
ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙДЫН
ТУШААЛ**

2011 оны 05 сарын 20 өдөр

Дугаар 151

Улаанбаатар хот

Гэрээний үлгэрчилсэн загвар батлах
тухай

“Төмөр замын тээврийн тухай” хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.15 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. “Суурь бүтэц эзэмшигч, тээвэрлэгч хоорондын хамтран ажиллах гэрээний үлгэрчилсэн загвар” - ыг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү загварыг хэрэгжүүлж ажиллахыг Төмөр замын газар /Т.Батболд/-т үүрэг болгосугай.

САЙД

Х.БАТТУЛГА

08 00330

Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын
сайдын 2011 оны... 05 сарын 20 өдрийн
151 дугаар тушаалын хавсралт

Суурь бүтэц эзэмшигч, тээвэрлэгч хоорондын хамтран ажиллах үлгэрчилсэн загвар

Нэг талаас /цаашид "тээвэрлэгч" гэх/ түүнийг төлөөлж
..... нөгөө талаас /цаашид "суурь
бүтэц эзэмшигч" гэх / түүнийг төлөөлж нар / цаашид
хамтад нь "талууд" гэх/ харилцан тохиролцож дараах нөхцөлтэйгээр энэхүү гэрээг
байгуулав.

Энэхүү гэрээний дагуу суурь бүтэц эзэмшигч нь тээвэрлэгчид өөрийн эзэмшлийн
суурь бүтцийг нийтийн хэрэглээний зам болон шаардлагатай бусад байгууламжуудыг
ашиглуулах, суурь бүтцийн хүрээнд хөдөлгөөний зохицуулалтыг хэрэгжүүлэх
үйлчилгээ үзүүлэх, тээвэрлэгч нь заагдсан үйлчилгээнд төлбөр төлөхтэй холбоотой
харилцааг зохицуулна.

Талууд Төмөр замын тээврийн тухай хууль тогтоомж, төмөр замын тээврийн
нийтлэг багц дүрмийг удирдлага болгон ажиллана.

Нэг. Гэрээний зүйл

Талууд үзүүлэх үйлчилгээ, тээвэрлэлтийн захиалга зөвшилцөх хугацаа, ачаа
болон зорчигч тээвэрлэлтийн төлөвлөгөө, ачааны эргэлтийн хэмжээ, аялалын чиглэл
болон бусад холбогдох зүйлсийг тохиролцон тусгана.

1. Үндсэн үйлчилгээ:

Суурь бүтэц эзэмшигч нь "Суурь бүтэц ашиглуулах журам"-д заасан дараах
үндсэн /...../ үйлчилгээг тээвэрлэгчид үзүүлнэ. Үүнд :

- 1.1. Суурь бүтэц эзэмшигчийн галт тэрэгний зурмаг /графикт/-аар үйлчлэх
галт тэрэгний тоо, чиглэл
- 1.2. Ачаа вагоны төрөл болон хэмжээ, эргэлт
- 1.3. Тээвэрлэлтийн технологи, хөлс, тариф
.....
2. Суурь бүтэц эзэмшигч нь дараах нэмэлт үйлчилгээг үзүүлнэ. Үүнд:
.....
3. Тээвэрлэлтийн захиалга зөвшилцөх журам, хугацаа
.....
4. Зурмаг, чиглэл
.....
5. Зорчигчийн галт тэрэг аялуулах хуваарь

.....
6. Ачааны төрөл болон эргэлтийн хэмжээ /нэг буюу олон удаа/
.....

7. Тээвэрлэлтийн технологи.....

Тээвэрлэгч нь тээвэрлэлт хийх захиалгыг тухай бүр Суурь бүтэц ашиглуулах журамд заасны дагуу суурь бүтэц эзэмшигчид ирүүлэх бөгөөд зөвшилцсөн захиалга, үйлчилгээний нөхцөл, хугацаа нь гэрээний хавсралт болно. Суурь бүтэц эзэмшигчийн үзүүлж буй үйлчилгээний нөхцөл, хугацааг тээвэрлэгч маягтын дагуу урьдчилан захиалсны үндсэн дээр харилцан тохиролцоно. Энэхүү захиалгын маягт нь гэрээний хавсралт болно.

Хоёр. Суурь бүтэц эзэмшигчийн эрх, үүрэг

- 2.1. Суурь бүтэц эзэмшигч нь тээвэрлэгч талтай галт тэрэгний хөдөлгөөн болон жингийн норм, даацыг тооцон хамтран зохион байгуулах
- 2.2. Гэрээнд заасан хугацаанд, захиалгын дагуу зохих ёсоор, бүрэн, чанартай үйлчилгээг үзүүлэх
- 2.3. Тээвэрлэгчийн хөдлөх бүрэлдхүүнийг суурь бүтэц эзэмшигчийн замд явуулах боломжоор хангах
- 2.4. Суурь бүтэц эзэмшигч нь өөрийн суурь бүтцийн хүрээнд тээвэрлэгчийн эзэмшлийн хөдлөх бүрэлдэхүүний ашиглалтын үзүүлэлтийг сайжруулах
- 2.5. Тээвэрлэлтийн хурдны тогтоогдсон ангиллын дагуу тээвэрлэгчийн галт тэрэгний хөдөлгөөний нөхцөлийг хангах шаардлагатай арга хэмжээг авах
- 2.6. Суурь бүтэц эзэмшигч нь өөрийн эзэмшлийн техник, тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдал болон аюулгүй ажиллагааг бүрэн хариуцах
- 2.7. Тээвэрлэгчийн хөдлөх бүрэлдэхүүнд техникийн үзлэг хийх
- 2.8. Суурь бүтэц эзэмшигч нь тээвэрлэгчийг тээвэрлэлтийн байршил, тээвэрлэлтийн үйл ажиллагаа ба вагон урсгал, зүтгүүр, вагоны эргэлтийн тохируулга, хугацаа болон үнэ тарифт гарах өөрчлөлттэй хялбартай үнэн бодит мэдээллээр хангах, үнэ, тариф, зурмаг, цагийн хуваарийн өөрчлөлт болон бусад мэдээллийг өгөх
- 2.9. Урьдчилан тааварлах боломжгүй нөхцөл байдал үүссэн, үйлчилгээ үзүүлэх боломжгүй нөхцөл байдал бий болсон бол тээвэрлэгчид нэн даруй мэдэгдэх, захиалгыг дахин зөвшилцөх
- 2.10. Суурь бүтэц эзэмшигч нь энэ гэрээнд заасан үйлчилгээний төлбөрийг тарифийн дагуу авах
- 2.11. Тээвэрлэгчийн тусгай зөвшөөрөл, бичиг баримтыг шалгах, шаардан гаргуулах
- 2.12. Гэрээнд заасан үйлчилгээний хөлс төлөхийг тээвэрлэгчээс шаардах

2.13. Хууль тогтоомжид заасан бусад эрх, үүргийг эдлэнэ.

Гурав. Тээвэрлэгчийн эрх, үүрэг

- 3.1. Гэрээнд заасан үйлчилгээний хөлсийг тарифын дагуу суурь бүтэц эзэмшигчид төлөх;
- 3.2. Суурь бүтэц эзэмшигчид үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн гэрчилгээ болон бусад баримт бичгийг танилцуулах, гэрээний хугацаанд тусгай зөвшөөрлийн хугацаа дуусах, хүчингүй болсныг тухай бүр мэдэгдэх;
- 3.3. Суурь бүтцийн технологийн болон нормативын шаардлагыг хангаж ажиллах, суурь бүтцийн аюулгүй ажиллагааг хангах талаар суурь бүтэц эзэмшигчээс тавьсан шаардлагыг биелүүлэх;
- 3.4. Захиалгын маягтад заасан үйлчилгээний хугацаа, нөхцлийг баримтлах;
- 3.5. Гэрээнд заасан үйлчилгээнээс татгалзах, өөрчлөх тохиолдолд суурь бүтэц эзэмшигчид хугацаанд урьдчилан бичгээр мэдэгдэх;
- 3.6. Суурь бүтцийн болон авч буй үйлчилгээг цаг тухайд нь чанартай биелүүлэх, түүний доголдлын талаар суурь бүтэц эзэмшигчид мэдэгдэх, арга хэмжээ авахуулахыг шаардах;
- 3.7. Гэрээнд заасан үйлчилгээнээс татгалзах, өөрчлөх тохиолдолд суурь бүтэц эзэмшигчид ажлын хоногийн дотор урьдчилан бичгээр мэдэгдэнэ;
- 3.8. Тээвэрлэгч нь ачаа, тээш, ачаан тээш болон зорчигчийг тээвэрлэх үйл ажиллагааг зөвшилцсөн захиалга, баталсан зурмагийн дагуу тогтоосон газар, хугацаанд нь зохих ёсоор гүйцэтгэх;
- 3.9. Тээвэрлэгч нь өөрийн эзэмшлийн техник тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдал болон аюулгүй ажиллагааг бүрэн хариуцах;
- 3.10. Ачаа эргэлт багассан, санхүүгийн хүндрэл үүссэн зэрэг хүндэтгэх шалтгаанаар тээвэрлэлтийн гэрээг тасалдуулах асуудал гарах тохиолдолд тээвэрлэгч тал гэрээг цуцлах болон өөрчлөлт оруулах талаар хоногийн өмнө суурь бүтэц эзэмшигчид албан ёсоор мэдэгдэнэ.
- 3.11. Тээвэрлэгч нь тээвэрлэлтийн үйл ажиллагаанаас талуудад учирч болох хохирлоос урьдчилан сэргийлэх зорилгоор хариуцлагын даатгалд даатгуулж энэхүү гэрээнд хавсаргасан байна.
- 3.12. Хууль тогтоомжид заасан бусад эрх, үүргийг эдлэнэ.

Дөрөв. Тариф хэрэглэх нөхцөл, нэмэлт үйлчилгээний хөлс

4.1. Үйлчилгээний тариф

.....

4.2. Хөнгөлөлт

.....

4.3. Нэмэлт үйлчилгээний хөлс

.....

4.4. Төлбөр тооцоо хийх журам

.....

4.5. Бусад

Тав. Тээвэрлэлтийг хэрэгжүүлэх

5.1. Тээвэрлэгч өөрийн эзэмшлийн хөдлөх бүрэлдэхүүнээр тээвэрлэлт хийх тохиолдолд гэрээнд заасан хугацаа, үйлчилгээ үзүүлэх нөхцлийн дагуу суурь бүтэц эзэмшигчийн өртөөний зам дээр өөрийн эзэмшлийн хөдлөх бүрэлдэхүүнийг техникийн үзлэг хийлгэхээр галт тэрэг хөдлөхөөс цагийн өмнө тавина.

5.2. Суурь бүтэц эзэмшигч тээвэрлэгчийн хөдлөх бүрэлдэхүүний бичиг баримт /натурный лист/ -ийг бөглөнө.

5.3. Суурь бүтэц эзэмшигч энэ хөдлөх бүрэлдэхүүн өртөөнөөс хөдлөх, замд явах, өртөөнд ирэх цаг, гэрээнд заасан бусад нөхцлийг хангана.

5.4. Хөдлөх бүрэлдэхүүний дайран өнгөрөх, зогсох бүх өртөө, зөрлөг дэхь суурь бүтэц эзэмшигчийн ажилтан / өртөөний жижүүр/ дагалдах бичиг баримтанд тухайн тээвэрлэгчийн хөдлөх бүрэлдэхүүний талаар холбогдох тэмдэглэгээг хийж баталгаажуулсан байна.

5.5. Хөдлөх бүрэлдэхүүний бичиг баримтын 1 хувь нь суурь бүтэц эзэмшигчид үлдэх ба энэхүү бичиг баримт нь үйлчилгээ үзүүлсний төлбөр тооцоог эцэслэн хийх үндэслэл болно.

5.6. Тээвэрлэгч нь өөрийн суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүнтэй тохиолдолд хиллэж байгаа аль нэг өртөөн дээр ачаа, галт тэрэг, вагон солилцох ажлын нэгдсэн технологийг хамтран боловсруулж, мөрдөн ажиллана.

Зургаа. Талуудын хариуцлага

6.1. Суурь бүтэц эзэмшигч нь энэхүү гэрээний 2 дугаар зүйлд заасан үүргээ биелүүлээгүй тохиолдолд тээвэрлэгчид учирсан хохирлыг арилгах үүрэгтэй.

6.2. Суурь бүтэц эзэмшигчийн буруугаас төмөр замын хөдөлгөөний зурмаг зөрчигдөн хөдлөх бүрэлдэхүүн саатсан тохиолдолд тээвэрлэгчид учирсан хохирлыг суурь бүтэц эзэмшигч хариуцана.